

Мэдээлэл

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 93,7 хувийн ирцтэйгээр хуралдлаа.

Хуралд:

- Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайланг хэлэлцэж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар уг тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг баталсан тухай тогтоол дугаар 01-ийг,
- Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаагүй хувьцааг хасах тухай асуудлыг хэлэлцэж хуралд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар уг хувьцааг хасахаар тогтсон тухай тогтоол дугаар 02,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийн тухай хэлэлцэж хуралд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар баталсан тогтоол дугаар 03,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай хэлэлцэж санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар ердийн гишүүдэд Б.Батмөнх, Б.Батбаатар, Ж.Батболд, Грам Чапман, Д.Даянбилгүүн, Жеймс Пассин нарыг, хараат бус гишүүдээр Д.Байлхүү, Кеннет Фаррелл, Жозеф Найэми нарыг сонгож баталсан тухай тогтоол дугаар 04-ийг тус тус баталлаа.
- Компанийн 2014 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсныг мэдээлж байна.

Хурал зохион байгуулах комисс

Харилцах утас: 976-11-311073, 99293913, 99031917

Электрон шуудан: otgonzul@sharyngol.com

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын талаарх мэдээлэл

“Шарын гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ. Энэ нь компанийн засаглалын үндсэн чиглэл байв.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2014 онд гишүүдийн оршин суугаа орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 11 удаа хуралдаж 19 тогтоол батлагдаж гарсан.

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ангилан авч үзвэл:

а. Компанийн 2014 оны бизнес төлөвлөгөө, компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цаашлын өрнөл хөгжлийг тодорхойлох 5 жилийн бодлого төлөвлөгөө боловсруулах ажлын комисс байгуулах тухай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой 4 асуудал.

б. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай аудитлагдсан санхүүгийн тайлангийн тухай, зээл авах тухай, гарын үсэг баталгаажуулах, түрээсийн гэрээ байгуулах, нүүрсний үнийг шинэчлэн тогтоох зэрэг компанийн санхүү эдийн засагтай холбоотой 9 асуудал.

в. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох, компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, томилох, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийг батлах, компанийн салбар төлөөлөгчийн газар байгуулах зэрэг компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 5 асуудал.

г. Шарын голын уурхай үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтаж хийх ажил, ойг тэмдэглэх бэлтгэл ажлын хэсэг байгуулах зэрэг бусад асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.

/Дэлгэрэнгүйг компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх, төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн аулын тайлангаас үзнэ үү./